

Батмөнхү даян хаан 48 жил суусан бөгөөд баруун 3 ястан, (цахар, халх) (Үр-син ан гуан) Зүүн 3 ястан бөгөөс 6 ястан хийгээд Хишигтэн (Өмнөх хошуу)-ийн (Онхон, Найман, Тэдэр, Алаг чигуан үзэмчин) арын 4, бөгөөс 8 хошуу хийгээд цэрэг 13 түмтийг эрхшээлдээ урвуулсан хэмээхүй, заримаас эрхэчиүдийн 2 тайж цэрэг луга сэлтэст Тайсүн хааны аймаг олноор алах цагт Тайсан хүүг Хартучагтиз хэмээхүй өчүүхэн охин луга хагацах бөгөөс Монгол орны хотон оронд зугатсанаас тэнд суухын цагт охин бие давхар болохын янар тэнд буйд хүн нэгэн гарсан дайсанг алахаас сэжигдэж, 2 тайж Маса мүрэгүнзи нэрт гэрээр монгол оронд дөхүүлэн сүүлд тэрний нэр Болоху жонон хэмээхүй тэр мөн хэмээхүй хийгээд зарим нэгэн тэр Даян хаахаанг мөн хэмээхүй үзэгдэхүйч Даян хаан бол Чингисийн уг дамжлага мөн нь магадтай хэмээгдэхүй. Хаан тэрээс Сайнмандухай хийгээд Самүр Тайху ба Бүсай хэмээхүй хатан 3 буйн Их хатны хөвгүүн Төрболод, Улусболод 2, Вачирболод, Алчуболод 2 (хөвгүүн Анзу Шараг 2) Алсугуар, Гангүн 12 бөгөөс 8 лүгэ датувур (татвар) эмд Гри болод, Гэрсэнз 2 луга өчүүхэн эмд Чинтайж Зигарүди (хүү үгүй) 2 нэлээд хөвгүүн 12 буй. Заримаас Хүсайгын дагуул эм ба Зимэгэнээс янагшихад бус бөгөөд хөвгүүн 11 хэмээхүй. Тэр хийгээд Түрболд нэг жил, түүний 2 хөвгүүнээс Бодиалаг хаан 13 жил, Түмэн засагт хаан 3 жил, Буянт цэцэн хаан 49 жил, Мандуй тайж 7 жил. (Лигдэн) Линдан хутагт 30 жил хаан ширээг зохиов хэмээжүү.

¹ Ишбалжир «Галбарвасан модун» IV бүлэг, 2 дахь тал

Д. Цэдэвийн монгол орчуулга (ДДСХ-ийн фонд)

² Эрдэнэтэй, Оюундалай (БНХАУ) «Монголын нууц товчоо» 190 дахь тал, 1980.

Хөх хот. (хятад хэлээр)

³ Дорнотив (БНХАУ) «Монголын нууц товчоо» 19 дэх тал, 1979, Хөх хот. . (хятад хэлээр)

⁴ Проф. Озово (Япон) «Монголын нууц товчоо» 3 дахь тал. 1984, Токио

⁵ Ц.Дамдинсүрэн «Монголын нууц товчоо»

⁶ Мөн тэнд

⁷ Дорнотив «Монголын нууц товчоо» I дахь тал, 1979, Хөх хот

МОНГОЛ, ВЬЕТНАМЫН ЭЛЧИН ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭЭС

С. Дашцэвэл

Монгол, Вьетнам хоёр улсын элчин харилцаа эртний уламжлалтай. «Их Вьет гүрний түүхийн бүрэн тэмдэглэл» хэмээх вьетнамын эртний нэгэн сурвалж бичигт «1168 оны шар хулгана жил татарын элч нийслэл Тханг Лонгд хүрэлцэн ирэв. Мөн үеэр Өмнөд Сүн улсын элч ирсэн тул 2 элчийг хооронд нь уулзуулсангүй»¹ хэмээжээ. Үүнээс үзвэл монгол, вьетнам хоёр улс лавтайяа 700 гаруй жилийн тэртээгээс бие биенээ мэддэг байжээ. Монголчуудыг тэр үед харь улс гүрнүүд «татар» хэмээн нэрлэж байсан бөгөөд вьетнамчууд ч гэсэн тийн нэрлэж

байсан нь эндээс тодорхой байна. Харин вьетнамыг монголчууд Гяожи улс хэмээн анх нэрлэж байсан байх юм. 1284 онд монгол жанжин Сугату зүүн өмнөд Азийн нэгэн нутгаас Хубилай хаанд өргөсөн бичигтээ: «Гяо-жи улс нь Жанлап (Одоогийн вьетнамын өмнөд хэсэгт байсан эртний улс), Чампа (вьетнамын дунд хэсэгт байсан улс), Дай-ли, Сиэм (тайланд) Миэн (Бирм) -тэй хил залгаа орших тул түүний газар дээр төвлөн сууваас тэндээс зардлыг гаргуулан цэргийн олон ноёдын хоол хүнсийг холоос зөөж төвөг удахгүй болно» гэж бичсэн нь чухамхүү вьетнамыг хэлжээ. Үүний дараахан Болд чинсан тэргүүтэй монгол түүхчдийн хамт Ираны түүхч Рашид-Ад-Диний бичсэн «Судрын чуулган»-д вьетнамыг мөн л Гяо-жи буюу перс аялгуунд Кяпча хэмээн нэрлэсэн бий.

«Ан нан улс эртний Гяо жи болой» гэж Юан улсын сударт бас тэмдэглэсэн байдаг.² Гяо-жи гэдэг нь угтаа биен дээрээ могой зурдаг, могой шүтдэг гэсэн утгатай эртний вьетнам үг ажээ. Харин хожмын түүх сурвалжид Ан нан хэмээх нэрээр голдуу нэрлэсэн үзэгдэнэ. Ан нан гэж төвшитгэн амирлуулагсан өмнөд нутаг гэсэн утгатай хятад үг.

1251 онд монголын хаан ширээнд өргөмжлөгдсөн Мөнх улсынхаа хилийг өмнө зүгт тэлэн өргөтгөх гэсэн эцэг Тулуй, авга Өгөдэйн бодлогыг үргэлжлүүлэв. 1253 онд Алтан улсын Өмнөд этгээдэд орших Дай-Ли буюу монголоор Хар зангуудын улсыг (одоогийн Хятадын баруун урд хэсэг буюу Юннань муж) монголчууд эзлээд вьетнамын хилд тулж очжээ. Энэ үед Монголын их гүрэнд хараахан эзлэгдээгүй үлдсэн өмнөд Сүн улсыг (одоогийн Хятадын зүүн өмнөд хэсэг) юуны өмнө эзлэн авахыг Мөнх хаан эрмэлзсэн учир Сүн улсын эсрэг хүч хавсрах бололцоо байгаа эсэхийг мэдэх зорилгоор Монголын элчийг вьетнамын нийслэлд илгээжээ. Энэ нь 1257 он байсан бөгөөд энэ үеэс (Мөнх, Хубилай, Өлзийт, Хайсанхүлэг, Буянт хаанаас Тогоонтөмөр хааныг хүртэлх арваад хааны үеийг дамжин) XIV зууны дунд үе хүртэл монгол, вьетнам хоёр улсын хооронд элч төлөөлөгчид харилцан тасралтгүй цувжээ.

Монголын хааны их нийслэл Хаан балгасан, Дээд нийслэл (Шанду) хотоос Вьетнамын нийслэл Тханг-лонг (одоогийн Ханой) хүртэлх олон мянган бээр газрыг мориор өртөөлөн туулж байв. Тэр үеийн элч нар голдуу Хятадын Сычуан, Юннань-аар дамжин Улаан мөрний сав газраар буюу «Баруун уртрагийн зам» уруудан вьетнамын баруун хойноос очдог байжээ. Хожим нь Сүн улсын нутгаар дайрч, баруун хойноос нь мөн далайгаар зуун талаас нь ч хүрэх болсон байна.

Монгол гүрний элч төлөөлөгчийг хаан өөрөө илгээж байснаас гадна вьетнамын ойролцоох улс ба хязгаар мужид сууж байсан цэргийн ноёд хааны нэрийн өмнөөс элч зарах явдал ч байв.

Тэр үед Монгол, вьетнамын хааны ордонд элч төлөөлөгчийг хүлээн авах нарийн тогтсон ёс дэгтэй байжээ.

Монголын Мөнх хаанд бараалхсан вьетнамын анхны элч нь вьетнамын цэргийн жанжин Ле фү Чан байв. Түүний дараа Хубилай хаанд вьетнамын олон элч төлөөлөгч удаа дараалан очжээ. Монголын хаан Вьетнамын элчийг ёс төртэй угтан авч хүндэлдэг байсан бөгөөд ирэх буцахад нь тусгай хүмүүс бараа болж хүнс, унаагаар үйлчилдэг байжээ.

1291 онд вьетнамд очсон Хубилай хааны нэгэн элчийн тэмдэглэлээс үзвэл монголын элчийг вьетнамын хаан угтан авахдаа хааны хэрмийн гол хаалгаар оруулдаг бөгөөд амар мэндийг мэдэхдээ эхлээд их хааны, дараа нь хааны шадар сайд нарын амар амгаланг асуун лавлаж эцэст нь ирсэн элчийн бие алжаасан эсэхийг асуудаг байжээ.

Үүний дараа сая хааны илгээсэн бичгийг гардан авч түүнд мөргөж танилцаад ирсэн элчтэй үг айлтгал солилцож дайллага хийж зоог барьдаг байжээ. Эдгээр тогтсон ёс горимыг ялимгүй зөрчвөөс хаан төрийг үл хүндэтгэж доромжилсон хэрэг болдог байв. Ийнхүү элч төлөөлөгчийг хүлээн авах ёс горим аль алинд нь бүр эрт дээр үеэс нэгэнт тогтсон зүйл байжээ.

Монгол, вьетнамын хаад өвөр хоорондоо олон арван бичиг захидал илгээж байсан бөгөөд түүний гол агуулга тэр үеийн түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэн үлдсэн нь цөөнгүй билээ.

Эдгээр бичиг захидлын агуулгаас үзвэл вьетнамын талаар явуулж байсан Монголын их гүрний бодлого нь эхлээд Өмнөд Сүн улсыг эзлэхэд вьетнам улсыг ашиглах, дараа нь өөрийн мэдэлд бүрэн оруулах явдал байв. Ийм бодлого явуулахдаа дэлхийн олон орныг эзэлсэн их гүрний сүр хүчийг ашиглаж «үгээр үхүүлж, сүрээр далайлгах» арга хэрэглэж байв. Ер нь тэр үеийн монгол гүрний хаад бусдыг заавал сөгдүүлэн захирах ёстой, бусад бүх орон хүлцэнгүй бууж өгөн захирагдах ёстой гэсэн үзэлд бат итгэж, тэр л үзэл бодлынхоо үүднээс вьетнамтай харилцаж байжээ. Гэвч цус урсган дайтахыг урьтал болгоогүй аль болохоор ятган ухуулах, айлган сүрдүүлэх замаар өөрийн харьяанд оруулахыг хичээж байсан нь элчийн олон бичгээс тодорхой байна.

Ялангуяа эхний үед (1258—1285) вьетнамыг зэвсгийн хүчээр биш дипломат аргаар дагаар оруулахыг нэн их чармайж байжээ. Энэ нь тухайн үеийн цэрэг дайны бодлого ялангуяа Өмнөд Сүн улсыг эзлэхийн төлөө явуулж байсан Хубилайн бодлого, мөн хоёр улсын цэргийн хүчний харьцаа, цэрэг дайны туршлага сэлттэй шууд холбоотой байжээ.

Тэр үед вьетнам улс хятадын ноёрхолоос ангижраад 200 шахам жил болчихсон феодалын нийгэм ид цэцэглэлтийн үедээ байв. Улс орныхоо тусгаар тогтнолын төлөө мянга шахам жилийн тэмцлийн үр дүнд туурга тусгаарлан хаад ноёд харц ард ялгалгүй улс орноо гэсэн эх оронч сэтгэл, үндэсний бахархал оргилуун байсан цаг ажээ. Гар үйлдвэр, уран дархан, зах зээл, худалдаа арилжаа муугүй хөгжсөн, ялангуяа далайн орнуудтай багагүй харилцаатай байсан вьетнам улс, төр улсаа хамгаалах бүхий л аргыг сүвэгчлэн дипломатын уран нарийн уян хатан арга хэрэглэж байжээ. Вьетнамын хаан хүчирхэг том гүрний их цэргийн аюул нөмрөхөөс улс орноо аврахын тулд зарим буулт хийж, тухайлбал 3 жилд 1 удаа алба барих³, даргач (захирагч) суулгахыг зөвшөөрч байв.

1262 оноос вьетнамын , нийслэлд Монголын даргач анх суужээ. Анхны даргач Нур-Уд-Дин хэмээх уйгур хүн байжээ. Даргач, дэд даргач, орлогчоос гадна тэднийг үйлчлэгч хүмүүс бас очдог байв. Тэд голдуу хоёр жилээр суудаг байв. Даргачийг буцахад, дэд даргач нь ихэнхдээ даргачаар дэвшин үлддэг байсан нь ажиглагдаж байна. Жишээ нь Нур-Уд-Дин-ий хойно Хүрэнхая, Яшина, Хасархаяа нар тийнхүү дараалан суужээ. Даргач нар тухайн орныг заншлан тандаж захиран суух үүрэгтэй боловч вьетнамд суусан даргач нар эрхээ эдлэх нөхцөлөөр тун муу байжээ. Учир нь тэднийг гадуур дотуур явж, хүн хартай уулзах бололцоог аль болохоор хязгаарлахыг хичээж байжээ.

Хубилай хаанаас вьетнамтай харилцаж байсан түүхийг үзвэл вьетнамын хааны зарим буултыг ашиглан эрхээ улам лавшруулж, улмаар тухайн орны улс төрийн бүрэн эрхийг гартаа авахын төлөө тэмцэж байжээ. Тухайлбал вьетнамыг шууд харьяаны улс болгох, түүний бүрэн эрхт байдлыг үгүйсгэхийн тулд 1-рт: Вьетнамын хааныг биеэр бараалхаж ирэхийг, 2-рт: Үр ач нараасаа авчирч хааны ивээлд

тушаахыг, 3-рт: Хүн амынхаа тоог өгч, цэргийн талаар монголын хаанд хүчин туслахыг тус тус шаардсаар байсан боловч вьетнамын хаан эс зөвшөөрч элдэв шалтгаан тоочсоор байжээ. Тийм учраас вьетнамыг бүрмөсөн өөртөө дагаар оруулахын тулд үе үе цэргийн хүчээр дайран орох явдал ч байжээ. Монголын Урианхадай, Ажу, Тогоон зэрэг цэргийн жанжнаар удирдуулсан довтолгоон 1257, 1285, 1288 онуудад болж, вьетнамын нийслэлийг эзэлсэн хэдий боловч удалгүй бут цохигдон буцсаар байв.

Рашид-Ад-Дин XIV зууны эхээр бичихдээ «Тэр улс (Гяо-жи) өөрийн хаантай бөгөөд монголын хааны эрхшээлд ороогүй» гэжээ.⁴

Энэ дашрамд тэмдэглэхэд Юан гүрний үед вьетнам улс алба барьж, даргач суулгаж байсан нь хоёр улсын хэлэлцээрийн үр дүн болохоос монголын Юан гүрний бүрэн захиргаанд орсны нотолгоо хараахан биш бололтой. Учир нь тэр үед ямар нэг хэмжээгээр төрийн бүрэн эрхээ хадгалж монголын хаанд элчээ илгээж тусгаар улсын ёсоор харилцсаар байжээ. XIV зууны монголын түүхийн сурвалж «Цагаан түүхэнд» монголын харьяанд байсан улсын нэрсийн дотор вьетнам байхгүй байгаа нь нэлээд бие даасан бодлоготой тусгаар улс байсны гэрч болов уу.⁵

«Хэн хүчтэйнх нь зөв» гэсэн бурангуй ёс ноёрхож, нэг нь хүчээр эзэн захирах, нөгөө нь тусгаар тогтнолоо хамгаалахын төлөө тэмцэлдэж байсан тэр үед хоёр ард түмний түүхэнд дурсамжтай хэрэг явдал ч бишгүйдээ байсан нь түүх сударт үлджээ. Жишээ нь Тогоон жанжны довтолгооны үед вьетнамд олзлогдсон монгол цэргийн нэгэн эмч вьетнамын хааны ордонд насаараа өвчтөнийг анагаан тусалж байсан бөгөөд түүний хүү бас л эцгийн ажлыг залгамжилж нэртэй оточ болсоныг «Их Вьет гүрний бүрэн тэмдэглэл»-д дурьджээ. Ер нь Хубилай хааны үед монголын уламжлалт эмнэлгийн ухаан хятад болон бусад орны эмнэлгийн арга ухаантай хослон баяжиж хөгжлийн шинэ илүү түвшинд хүрсэн нь маргаангүй бөгөөд зүү тавих арга ихэд дэлгэрч байсан түүхтэй. 1305 онд монголын хаан вьетнамын хаанд «эм тан ба зүү тавьж өвчнийг анагаахуй» номыг өгч байсан мэдээ байгаа нь зүүн эмчилгээ муугүй хөгжиж байсныг нотолж байна. Үүнээс гадна вьетнамын хааны ордонд монголын цэргээс олзлогдон үлдсэн нэгэн дуучин хүн ихэд хүндлэгдэн байсан удаатай. Тэр хүний тухай вьетнам сударт: «Тэрбээр жүжиглэн дуулахдаа гоц авьяастай. Хар бар жилийн хавар (1362 онд) хааны ордонд хатагтай гүнж нарыг зугаацуулах наадам үзүүлэх уралдаан зарлахад 12 хүнийг оролцуулсан дуут жүжиг найруулан тоглов. Тоглогчид хээ хуар бүхий торгон өмсгөл өмсч бөмбөр цохин, лимбэ үлээж, хуур наадан, алга ташин гарч орон солигдож дуулж жүжиглэнэ. Үзэгч олныг уйтгарлуулж ч чадна, баясуулж ч чадах амой. Манай улсад тэр цагаас Туонг хэмээх дуулалт жүжиг буй болов» гэжээ. Вьетнамд «Туонг» хэмээх сонгодог театрын нэгэн төрөл одоог хүртэл хөгжиж ирсэн бөгөөд үүнийг үүсгэн буй болгоогүй юмаа гэхэд өмнө зүгийн оронд дуут бүжгийг хөгжүүлэх үйлсэд багагүй хувь нэмэр оруулсан нь илт байна.

Үүнээс гадна Вьетнамын түүхч түшмэл Ле Чак монголын хааны дэргэдэх түүх шаштир зохиох газар ажиллаж, вьетнам, монголын харилцааны нэлээд тодорхой баримтуудыг халуун сэргэг дээр нь тэм дэглэн үлдээсэн «Вьетнамын хураангуй тэмдэглэл» хэмээх түүхийн тэмдэглэл зохиосон нь өнөөг хүртэл хадгалагдан түүхийн чухал сурвалж бичиг болон үлджээ.

Ийнхүү монгол, вьетнамын элчин хийгээд соёлын харилцаа, эртний уламжлалтай.

¹ Ngo si Lien, Dai Viet su ky, Toan thu I t 289.

² Юан улсын судар. (Гар бичмэл). 209-р дэвтэр

³ 1261 оноос вьетнамын хаан бэлэг сэлт ба алба барьж эхэлсэн бөгөөд Хубилай хаан бичгийн түшмэл, оточ, зурхайч, уран дархцуул тус бүр гутгаарыг алт, мөнгө, шүр сувд, тансаг үнэртэн, зааны соёо, хярсны эвэр, бөс, ваар шаазангийн хамт илгээхийг шаардаж байсан боловч вьетнамын хаан эд юмсыг зааны хамт өгч харин хүн.илгээхийг үл тэвчжээ.

⁴ Рашид-Ад-дин. Сборник Литописей. II. том. с. 184

⁵ Цагаан түүхэнд «Tügün-u panggyiad» гэж нэр байгаа бөгөөд академич Ш. Бира түүнийг вьетнамтай холбон тайлбарласан буй. Миний бодоход 13-р зуунаас вьетнамтайн нягт харилцаж, улсын нэрийг Гяо-жи, Ан нан гэж тов тодорхой бичсээр хэлцсээр ирсэн атлаа « Tügün-u panggyiad» буюу өмнөд хятадын улстай гэнэт хамтатган нэрлэх учиргүй мэт. Цагаан түүхийн тухай «Түүхийн цуврал» УБ., 1967

**МАХН ХЯТАДЫН
1924—1927 ОНЫ
ХУВЬСГАЛЫГ ДЭМЖИЖ
БАЙСАН НЬ**

Л. Жамсран

Манай намыг жинхэнэ байгуулсан анхдугаар их хурлаар баталсан намын мөрийн хөтөлбөрт; «...Манай Монгол Ардын Намын эрмэлзэх нь алсдаа монгол үндэстэн бүгдээр нийлж, нэгэн улс болохыг хүснэ. Одоо даруй Хятадын харгис мэдлээс ангижирч, сая мөхсөн автономит Гадаад Монголын төрийг дахин шинэчлэн босгохыг зорино»¹ гэж алдагдсан үндэсний нэгдэл, устгагдсан автономит төрөө дахин босгох тэгэхдээ «шинэчлэн» гэдэг нарийн учиртай санааг хэн бүхэнд ойлгомжтойгоор зорилтоо болгон тодорхойлон заасан юм. Гэхдээ энэ хэргийг гүйцэтгэхийн тул бусад орны ялангуяа хөрш Хятад, Оросын хувьсгалт олон түмэн хийгээд тэдгээрийн намуудтай ажил хэргийн холбоо тогтоож, дэмжлэг тусламж авахыг ихэд чухалчилж байсан тул мөнхүү мөрийн хөтөлбөрт; «Манай Монгол Ардын Намд адил харгисыг халах, боловсролыг урагш давшихыг эрмэлзэх, ард иргэний эрхийг нийтэд тэгшлэн засах хэмээсэн Хятад, Оросын зэрэг гадаад олон улсын хувьсгалчны намууд лугаа нэвтрэлцэн найрамдаж харилцан туслалцахыг хичээнэ»² гэж заасан. Ингэж МАХН анх байгуулагдахаасаа эхлэн хятадын харгис хүчийг эсэргүүцэж, хувьсгалт ардчилсан хүчинтэй найрсаг харилцаж, тэдний тус дэмжлэгтэйгээр өмнө тавьсан зорилтоо хэрэгжүүлж, үндэсний тусгаар тогтнолоо байлдан олж, шинэ амьдрал байгуулахын төлөө тэмцсэн юм. Тэгэхдээ 1921 оны гуравдугаар сарын 25-нд Хятадын хувьсгалч хүчинд хандаж гаргасан уриалгадаа: «...дотоод гадаадын харгисуудад нэгэн адил дарлагдан мөлжлөгдөж байгаа хятад, монголын ард түмний эрх ашиг гүнээ ижил тул Монголд цэрэг илгээхээ нэн даруй зогсоохыг МАН-ын Төв Хороо, Монголын